

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ БОЛОН ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСГИЙГ  
ДЭЛГЭРҮҮЛЭХИЙГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ БАНКНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД МОНГОЛБАНКНААС ГАЗАР ДЭЭРХ  
ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх /цаашид МУТС гэх/-тэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, бусад хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанкнаас гаргасан заавар, дүрэм, журам, удирдамж, зөвлөмжийг банк өөрийн бүтэц зохион байгуулалт, бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийг харилцагчид хүргэх арга хэлбэр болон үйл ажиллагааны цар хүрээтэй уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлж, МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан газар дээрх хяналт шалгалт хийх, дүгнэлт гаргахад энэ журмыг мөрдлөг болгоно.

1.2 Зайны хяналтын дүгнэлтэд үндэслэн газар дээрх хяналт шалгалт хийгдэх банк болон газар дээрх шалгалтын чиглэлийг тодорхойлно.

1.3 МУТС-тэй тэмцэх чиглэлээр банканд хийгдэх газар дээрх хяналт шалгалтын удирдамжийг Монголбанкны Ерөнхийлөгч батална.

1.4 Газар дээрх хяналт шалгалтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1.4.1 Газар дээрх хяналт шалгалтыг бэлтгэл ажлыг хангах;

1.4.2 Газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх;

1.4.3 Газар дээрх хяналт шалгалтын дараах үйл ажиллагааг зохион байгуулах

1.4.4 Бусад үйл ажиллагаа;

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ

2.1 Хянан шалгагч нь газар дээрх хяналт шалгалтыг хийхийн өмнө дараах баримт, мэдээлэлтэй танилцсан байх шаардлагатай. Үүнд:

2.1.1 Банкны МУТС-тэй тэмцэх эрсдэлийн үнэлгээний тайлан;

2.1.2 Өмнөх хяналт шалгалтын тайлан, өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт;

2.1.3 Банкны дотоод болон хөндлөнгийн аудитын тайлан;

2.1.4 Зайны хяналт шалгалтын тайлан;

2.1.5 Шаардлагатай бусад мэдээлэл.

2.2 Газар дээрх хяналт шалгалтын бэлтгэл ажлыг гарын авлагад заасны дагуу гүйцэтгэнэ.

2.3 Банканд газар дээрх хяналт шалгалт хийхийн өмнө шалгалтын удирдамж, урьдчилан бэлтгэх баримт материалын жагсаалт /хавсралт-1/-ыг банкны удирдлагад танилцуулж, холбогдох мэдээллийг гаргуулж авна.

#### ГУРАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨРӨЛ БА ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛ

3.1 Банканд МУТС-тэй тэмцэх чиглэлээр хийх эрсдэлд суурилсан газар дээх хяналт шалгалтыг дараах байдлаар ангилна. Үүнд:

3.1.1 Иж бүрэн хяналт шалгалт: Энэ журмын 3.3-т заасан 20 чиглэл болон шаардлагатай нэмэлт чиглэлүүдийг сонгож хийх хяналт шалгалт;

3.1.2 Хэсэгчилсэн хяналт шалгалт: Энэ журмын 3.3-т заасан 20 чиглэлээс сонгогдсон эрсдэлд суурилсан хэлбэрээр хийх хяналт шалгалт;

3.1.3 Гүйцэтгэлийн хяналт шалгалт: Зайны болон газар дээрх хяналт шалгалтын хүрээнд өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгах хяналт шалгалт;

3.1.4 Сэдэвчилсэн хяналт шалгалт: Тухайлсан сэдвээр хийх хяналт шалгалт;

3.1.5 Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын дагуу хийх хяналт шалгалт;

3.2 Банканд МУТС-тэй тэмцэх чиглэлийг үндсэн болон нэмэлт гэж 2 бүлэгт хуваана.

3.3 Банкны МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалт хийх үндсэн чиглэлд дараах үзүүлэлтүүд багтана. Үүнд:

3.3.1 МУТС-тэй тэмцэх банкны бүтэц зохион байгуулалт, ТУЗ болон түүний дэргэдэх хороодын оролцоо, дотоод бодлого, журам;

3.3.2 Хэрэгжилт хариуцсан ажилтан, нэгж, тэдгээрийн чиг үүрэг;

3.3.3 Харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээ түүнийг харилцагчид хүргэх арга хэлбэр, үйл ажиллагааны цар хүрээ, газар зүйн онцлогоос үүдэн гарах МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлэх аргачлал түүний үр дүнтэй байдал;

3.3.4 Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа;

3.3.5 Харилцагчийг нарийвчлан таньж мэдэх үйл ажиллагаа;

3.3.6 Эцсийн өмчлөгчийг тогтоох, таньж мэдэх үйл ажиллагаа;

3.3.7 Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаанд гуравдагч этгээдийг ашиглах;

- 3.3.8 Улс төрд нөлөө бүхий этгээдийг таньж мэдэх, хяналт тавихтай холбоотой банкны үйл ажиллагаа;
  - 3.3.9 Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, Үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа болон өндөр эрсдэлтэй орнуудад авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа;
  - 3.3.10 Банк бус санхүүгийн байгууллага болон бусад мэдээлэх үүрэгтэй этгээд харилцагчид авах арга хэмжээ;
  - 3.3.11 Данс, гүйлгээнд тусгайлан хяналт тавих үйл ажиллагаа;
  - 3.3.12 Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх банкны үйл ажиллагаа;
  - 3.3.13 Бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээг мэдээлэхтэй холбоотой үйл ажиллагаа;
  - 3.3.14 Хил дамнасан корреспондент банкны үйл ажиллагаа;
  - 3.3.15 МУТС-тэй тэмцэхэд чиглэсэн банкны дотоод хяналт, шалгалтын тогтолцоо, арга хэлбэр;
  - 3.3.16 Цахим гүйлгээнд тавих хяналт;
  - 3.3.17 Шинэ технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаа ба виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээс үүсэх эрсдэл;
  - 3.3.18 Баримт, материалын хадгалалт;
  - 3.3.19 МУТС-тэй тэмцэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр түүний хэрэгжилт;
  - 3.3.20 Харилцагчийг таньж мэдэх хялбаршуулсан үйл ажиллагаа.
- 3.4 Хянан шалгагч банкны МУТС, үй олноор зэвсэг дэлгэрүүлэхтэй холбоотой эрсдэлээс хамаарч нэмэлт чиглэлээр хяналт шалгалт хийж болно.
- 3.4.1 Хяналт шалгалтын чиглэлийг өргөжүүлэхдээ эрсдэлд суурилсан хандлагыг ашиглана.
  - 3.4.2 Нэмэлт хяналт шалгалтын чиглэлүүдийг хавсралт-2-т жилд 1 удаа тусгана.
  - 3.4.3 Нэмэлт хяналт шалгалтын чиглэлийг өргөжүүлэх, шинэчлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой хөгжүүлэлтийг байнгын хийж гүйцэтгэнэ.
- 3.5 Хянан шалгагч нь 3.1-д дурдсан чиглэлээр хяналт шалгалт хийхдээ энэ журмын аргачлалыг ашиглахын зэрэгцээ өмнөх газар дээрх шалгалт болон зайнаас тавих хяналтын хүрээнд өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, банкнаас өгсөн статистик мэдээлэл, хяналт

шалгалтын гарсан үр дүн зэрэгт үндэслэн хяналт шалгалтын аргачлалыг байнгын шинэчилж байна.

3.6 Үндэсний эрсдэлийн үнэлгээ болон Монголбанкны зүгээс тодорхойлсон МУТС болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй холбоотой эрсдэлийг харгалзан 3.3-д заасан аргачлалд өөрчлөлт, нэмэлт оруулж болно.

3.7 Хянан шалгагч үндсэн болон нэмэлт чиглэлээр хяналт шалгалт хийхдээ холбогдох аргачлал, гарын авлагыг ашиглана.

## ДӨРӨВ. ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТЫГ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭХ

4.1 Хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхэд дараах дарааллыг баримтлана. Үүнд:

4.1.1 Хяналт шалгалтыг эхлүүлэх уулзалтыг зохион байгуулах, Хяналт шалгалтын удирдамжийг банкны удирдлагуудад танилцуулах,

4.1.2 Хяналт шалгалт хийхэд шаардлагатай мэдээллийг хавсралт-1-т заасан маягтын дагуу гаргуулж авах;

4.1.3 Газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэх;

4.1.4 Хяналт шалгалтыг дүгнэх, хяналт шалгалтын урьдчилсан тайланг боловсруулах;

4.1.5 Хяналт шалгалтын тайлан, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг танилцуулж, шаардлагатай бол санал, тайлбар авах (feedback)

4.1.6 Банкны удирдлагуудад шалгалтын тайлан, акт, материалыг танилцуулах;

4.2 Газар дээрх хяналт шалгалтыг гүйцэтгэхэд дараах арга хэмжээг авна. Үүнд:

4.2.1 Хяналт шалгалтыг эхлүүлэх уулзалтаар хяналт шалгалтын зорилго, цар хүрээ, гүйцэтгэлтэй холбоотой, мэдээлэл солилцох, хүлээж авахтай холбоотой цаг хугацааг тохирно.

4.2.2 Журмын 4.1.3-т заасан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхэд журмын 3 дугаар бүлэгт заасан аргачлалыг баримтлах ба бусад хяналт шалгалтын техникийг ашиглаж болно.

4.2.3 Журмын 4.1.4-т заасны дагуу ажлын хэсэг хяналт шалгалтын явцыг хэлэлцэх, үр дүнг тайлагнах, хяналт шалгалтын тайланг боловсруулахдаа энэ журмын хавсралт-3-д заасан хяналт шалгалтын тайлангийн загварыг ашиглаж болно.

4.2.4 Хяналт шалгалтын тайланг удирдамжид заасан хугацаанд танилцуулж, баталгаажуулна.

4.3 Хяналт шалгалтын тайланг дүгнэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

4.3.1 Хянан шалгагч хийсэн хяналт шалгалтын чиглэл тус бүрээр үнэлгээ өгнө.

4.3.2 Үнэлгээг өгөхдөө дараах хүснэгтийг ашиглана. Үүнд:

Үнэлгээ	Үнэлгээний тайлбар
1	Ямар ч алдаа, дутагдал байхгүй. Хянан шалгагчийн үнэлгээ, шинжилгээ хийж өгсөн асуулгын хариултад алдаа дутагдал байхгүй, Банк нь хуулийн шаардлагыг бүрэн хангасан бодлого, дотоод журамтай бөгөөд дотоод хяналтын тогтолцоо, үйл ажиллагаа нь (удирдлагын хяналт, хэрэгжилт гэх мэт) маш сайн. Мөн Хянан шалгагч нь тухайн байгууллагын талаарх өмнөх мэдээлэл, туршлага /хяналт шалгалтаар олж авсан мэдээлэл/-даа үндэслэн энэ үнэлгээг өгөх нь зохистой, нийцтэй гэж үзсэн.
2	Банкнаас ирүүлсэн хариултад дүн шинжилгээ хийхэд бага зэрэг зөрчил дутагдалтай, банк нь хуулийн гол шаардлагууд болох дотоод бодлого журмын хөгжүүлэлт, үйл ажиллагаа, удирдлагын хяналт, хэрэгжилт зэргийг үр дүнтэй байхаар тодорхойлсон, илэрсэн зөрчил дутагдлыг газар дээрх хяналт шалгалт болон удирдлагад үүрэг даалгавар өгч арилгуулах боломжтой. Мөн Хянан шалгагч нь тухайн байгууллагын талаарх өмнөх мэдээлэл, туршлага /хяналт шалгалтаар олж авсан мэдээлэл/-даа үндэслэн энэ үнэлгээг өгөх нь зохистой, нийцтэй гэж үзсэн.
3	Банкнаас ирүүлсэн хариултаас тодорхойлоход хуулийн шаардлагад нийцээгүй бөгөөд энэ дунд зэргийн зөрчил дутагдал бол, Бодлого, журам нь банкны үйл ажиллагааны бүх талыг хамарч чадаагүй, удирдлагын хяналтын тогтолцоо нь хангалттай мэт боловч бүрэн үр дүнтэй байдал нь эргэлзээтэй. Жнь: Ажилтнуудын тайлагнал, баталгаажуулалтыг хууль журмын хүрээнд нийцүүлэх шаардлагатай. Мөн хянан шалгагч нь тухайн байгууллагын талаарх өмнөх мэдээлэл, туршлага /хяналт шалгалтаар олж авсан мэдээлэл/-даа үндэслэн энэ үнэлгээг өгөх нь зохистой, нийцтэй гэж үзсэн.
4	Банкны бодлого, журамд хуулийн шаардлагыг тусгахдаа хуулийн ихэнх хэсгийг хангаж чадаагүй, энэ тал дээр ихээхэн дутагдалтай, Жнь: ХТМ үйл ажиллагааны шаардлага нь хуульд нийцээгүй, банк өндөр эрсдэлтэй харилцагч, бизнесийн харилцааг тодорхойлдоггүй, МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаанд удирдлага, ТУЗ-ийн оролцоо хязгаарлагдмал. Мөн Хянан шалгагч нь тухайн байгууллагын талаарх өмнөх мэдээлэл, туршлага /хяналт шалгалтаар олж авсан мэдээлэл/-даа үндэслэн энэ үнэлгээг өгөх нь зохистой, нийцтэй гэж үзсэн.
5	Ихээхэн алдаа дутагдалтай. Бодлого, журам нь хуулийн шаардлагад нийцээгүй, удирдлага болон ТУЗ-ийн хяналт маш муу, дотоод хяналтын болон тайлагнах механизм дутагдалтай, бие даасан комплаенсийн бүтэц байхгүй, ажилтнуудад сургалт хийдэггүй г.м олон дутагдалтай. Мөн Хянан шалгагч нь тухайн байгууллагын талаарх өмнөх мэдээлэл, туршлага /хяналт шалгалтаар олж авсан мэдээлэл/-даа үндэслэн энэ үнэлгээг өгөх нь зохистой, нийцтэй гэж үзсэн.

4.4 Хяналт шалгалтын үнэлгээгээр 3 болон түүнээс хангалтгүй үнэлгээ авсан бөгөөд зөрчлийн шинжгүй бол дутагдлыг сайжруулахтай холбоотой дараах арга хэмжээг авна.

4.4.1 дутагдлыг засах, урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөмж өгөх;

4.4.2 илэрсэн дутагдлыг дахин үйлдэхээс сэргийлэх зорилготой бол сануулга өгөх;

4.4.3 дутагдлыг арилгуулахтай холбоотой хугацаатай үүрэг, даалгавар өгөх;

4.5 Зөрчлийн хуульд зааснаас бусад тохиолдолд, өмнө нь илэрсэн дутагдлыг засч сайжруулах арга хэмжээ аваагүй, эсхүл дутагдлыг дахин гаргасан тохиолдолд тухайн алдаа, дутагдлын үр нөлөөг харгалзан дараах хүснэгтэд заасны дагуу арга хэмжээ авна. Үүнд:

Алдаа дутагдлын давтамж/ авах арга хэмжээ	1 удаа	2 удаа	3 удаа болон түүнээс дээш
Авах арга хэмжээ	Сануулга өгөх, албан шаардлага хүргүүлэх	Хугацаатай үүрэг даалгавар өгөх	Зөрчлийн арга хэмжээ авах

#### ТАВ. ТАЙЛАГНАЛ, ШАЛГАЛТЫН МӨРӨӨР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

5.1 Ажлын хэсэг шалгалтын танилцуулга, шалгалтаар тухайн банканд авсан арга хэмжээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа “Монголбанкны Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөлийн хурал”-д танилцуулна.

5.2. “Монголбанкны Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөлийн хурал”-аас гаргасан санал, дүгнэлтэд үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал гаргана.

5.3. Шалгалт хийгдсэн банканд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалыг хүргүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллана.

#### ЗУРГАА. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН ҮҮРЭГ

6.1 Газар дээрх хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч, гишүүд нь Төв банк /Монголбанк/-ны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан эрх үүргийг хэрэгжүүлж, улсын байцаагчийн үйл ажиллагаандаа мөрдөх зарчмыг баримтлан ажиллана.

6.2 Газар дээрх шалгалттай холбоотой гомдол, санал, тайлбарыг хүлээн авах, шийдвэрлэхэд Монголбанкны улсын байцаагчийн дүрмийг баримтална.

6.3 Хяналт шалгалтын ажлын хэсгийн ахлагч нь дараах үүрэгтэй. Үүнд:

6.3.1 шалгалтын чиглэл, удирдамжийн талаар банкны Гүйцэтгэх удирдлага болон холбогдох нэгжийн удирдлагуудад ажилтнуудад танилцуулж, мэдээлэл хийж урьдчилан бэлтгэх баримт, материалын жагсаалтыг бэлтгэн танилцуулна;

6.3.2 хянан шалгагч нарын ажил үүргийн хуваарийг хийж, шалгалтын явцад хянан шалгагч нарын ажилтай танилцаж, заавар зөвлөгөө өгч, шалгалтыг хугацаанд нь дуусгах талаар санаачилга гарган ажиллана;

6.3.3 нэмэлт хугацаа шаардлагатай бол энэ талаар удирдлагад хүсэлт гаргана;

6.3.4 хяналт шалгалт хийж дууссаны дараа дууссанаас хойш ажлын долоон өдөрт багтааж шалгалтын акт материал болон шалгалтын мөрөөр авах арга хэмжээний саналыг Монголбанкны Хяналт шалгалтын зөвлөлд танилцуулахад бэлэн болгоно;

6.3.5 ажлын хэсгийн ахлагч шалгалтын акт материалыг Монголбанкны Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж, түүний гаргасан саналын дагуу мөрөөр Монголбанкны Ерөнхийлөгчийн гаргасан гарсан шийдвэрийг банканд хүргүүлэх арга хэмжээг авсны дараагаар банкны эрсдэлийн үнэлгээг шинэчлэн шалгалтын акт материалыг банкны хувийн хэрэгт хавсаргана.

6.4 Хяналт шалгалтын ажлын хэсэг шалгалтын танилцуулга, шалгалтаар тухай банканд авч арга хэмжээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа “Монголбанкны Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөлийн хурал”-д танилцуулж ажлын тайланг эцэслэнэ.

6.5 Хяналт шалгалтын ажлын хэсэг “Монголбанкны Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавих зөвлөлийн хурал”-д хяналт шалгалтын тайланг танилцуулж, гаргасан санал, дүгнэлтэд үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал гаргана.

#### ДОЛОО. ХАРИУЦЛАГА

7.1 Энэхүү журмыг зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

7.2 Хянан шалгагч илэрсэн зөрчил дутагдал эрүүгийн шинжтэй бол холбогдох журмын дагуу хууль сахиулах байгууллагад шилжүүлнэ.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_